ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

# Өмнөговь аймгийн Хүрмэн сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2026/101/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.Umnugovi@audit.mn

Өмнөговь аймаг

2026 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Болормаа
Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn
Аудитор: П.Санчиргарав
Утас: 70533552 Цахим хаяг: Sanchirgaravp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ


**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn


2026.02.25 № 187

танай ______________-ны №______________ -т

ХҮРМЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Д.ХҮРЛЭЭ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүрмэн сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1,760,499.1 мянган төгрөгийн бараа материал, үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгасан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Орон нутгийн төсвөөс 118,789.9 мянган төгрөгийн орон нутгийн нэмэгдэл, 78,288.6 мянган төгрөгийн нутгийн дэмийн урамшууллын олгосон байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 7 зорилтын хүрээнд 74 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 95.6 хувийн гүйцэтгэлтэй дүгнүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

4626050305

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ӨСӨХБАЯР

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*/төгрөг/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **243,758,131.0** | **210,841,826.5** |
| **33** | **АВЛАГА** | 5,264,195.0 | 21,047,354.0 |
| **33300** | Татаас, санхүүжилтийн авлага | - | 15,783,159.0 |
| **335** | **Бусад авлага** | 5,264,195.0 | 5,264,195.0 |
| **3352** | Хувь хүмүүсээс авах авлага | 5,264,195.0 | 5,264,195.0 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 238,493,936.0 | 189,794,472.5 |
| **351** | **Түүхий эд материал** | 77,502,118.0 | 77,502,118.0 |
| **35110** | Тусгай зориулалттай материал | 77,502,118.0 | 77,502,118.0 |
| **354** | **Хангамжийн материал** | 128,922,133.0 | 77,422,669.5 |
| **35410** | Бичиг хэргийн материал | 216,735.0 | - |
| **35420** | Аж ахуйн материал | 57,514,265.0 | 14,278,771.5 |
| **35430** | Сэлбэг хэрэгсэл | 6,304,000.0 | - |
| **35440** | Түлш, шатах тослох материал | - | 0.0 |
| **35470** | Бусад хангамжийн материал | 64,887,133.0 | 63,143,898.0 |
| **35600** | Мал амьтад | 32,069,685.0 | 34,869,685.0 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **10,237,709,346.6** | **11,405,100,331.0** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 10,237,709,346.6 | 11,405,100,331.0 |
| **392** | **Биет хөрөнгө** | 9,305,696,081.9 | 10,472,070,399.6 |
| **39201** | Барилга, байгууламж, орон сууц | 6,324,936,819.2 | 6,510,070,436.2 |
| **39202** | Хуримтлагдсан элэгдэл | (890,878,715.5) | (1,121,927,372.7) |
| **39203** | Авто-тээврийн хэрэгсэл | 334,626,800.0 | 418,506,800.0 |
| **39204** | Хуримтлагдсан элэгдэл | (124,172,355.8) | (189,422,133.6) |
| **39205** | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 548,858,927.6 | 500,469,425.5 |
| **39206** | Хуримтлагдсан элэгдэл | (341,297,651.9) | (233,265,977.7) |
| **39207** | Тавилга, аж ахуйн эд хогшил | 187,441,297.7 | 192,286,297.7 |
| **39208** | Хуримтлагдсан элэгдэл | (65,255,631.2) | (84,715,636.2) |
| **39209** | Зам, гүүрний байгууламж | 539,100,127.0 | 1,726,088,567.0 |
| **39210** | Хуримтлагдсан элэгдэл | (537,433,460.4) | (537,433,460.4) |
| **39213** | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 100,772,000.0 | 100,772,000.0 |
| **39214** | Бусад үндсэн хөрөнгө | 3,350,589,339.5 | 3,609,757,004.5 |
| **39215** | Хуримтлагдсан элэгдэл | (121,591,414.4) | (419,115,550.8) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 932,013,264.7 | 933,029,931.4 |
| **39301** | Программ хангамж | 2,375,000.0 | 2,375,000.0 |
| **39302** | Хуримтлагдсан элэгдэл | (1,758,333.3) | (741,666.6) |
| **39303** | Бусад биет бус хөрөнгө | 931,396,598.0 | 931,396,598.0 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **10,481,467,477.6** | **11,615,942,157.5** |
| **413** | **Өглөг** | 95,640,100.0 | - |
| **41320** | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 2,357,000.0 | - |
| **4136** | **Бусад өглөг** | 93,283,100.0 | - |
| **41362** | Хувь хүмүүст төлөх өглөг | 93,283,100.0 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **10,385,827,377.6** | **11,615,942,157.5** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 10,385,827,377.6 | 11,615,942,157.5 |
| **511** | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 682,319,235.8 | 681,754,235.8 |
| **51101** | Өмч: - төрийн | 682,319,235.8 | 681,754,235.8 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 9,534,036,648.9 | 10,764,716,428.9 |
| **51210** | Өмнөх үеийн үр дүн | 9,534,036,648.9 | 9,533,969,982.3 |
| **51220** | Тайлант үеийн үр дүн | - | 1,230,746,446.6 |
| **51300** | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 169,471,492.9 | 169,471,492.9 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **10,481,467,477.6** | **11,615,942,157.5** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **5,416,695,564.0** | 3,902,280,554.93 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,931,800,103.0** | 3,902,280,554.93 |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 3,931,800,103.0 | 2,009,012,492.93 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,190,000 | 4,939,000 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,190,000 | 4,939,000 |

| | | | |
|---|---|---|---|
| 120012 | Эрхийн шимтгэлийн орлого /ТӨҮГ/ | 3,923,116,418 | |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 3,923,766,418.0 | 1,760,499,065.9 |
| 120011 | Борлуулалтын өртөг /ТӨҮГ/ | 8,033,685.0 | 78,703,266.0 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,484,895,461.0** | **1,893,268,062.0** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 199,530,661.0 | 214,687,532.0 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 181,211,546.0 | 208,642,728.0 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 14,537,115.0 | 2,566,004.0 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,782,000.0 | 3,478,800.0 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 1,285,364,800.0 | 1,678,580,530.0 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,285,364,800.0 | 1,678,580,530.0 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,977,157,194.9** | **2,624,720,408.4** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,977,157,194.9** | **2,588,677,519.4** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,705,974,364.1 | 2,160,358,607.1 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 587,670,617.4 | 745,933,273.0 |
| 210101 | Үндсэн цалин | 303,189,410.1 | 332,920,857.0 |
| 210102 | Нэмэгдэл | 214,714,762.5 | 312,895,528.0 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 12,325,255.3 | 17,714,936.8 |
| 210104 | Урамшуулал | 57,441,189.6 | 69,064,372.0 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 13,337,579.2 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 85,460,582.0 | 110,681,760.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 58,113,123.5 | 83,334,677.9 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,749,451.7 | 8,068,110.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,556,914.9 | 2,650,537.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,367,363.2 | 4,139,862.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,673,728.8 | 12,488,573.1 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 74,930,603.7 | 79,566,796.7 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 13,295,083.0 | 13,437,368.9 |
| 210302 | Түлш, халаалт | 60,285,520.7 | 61,479,427.8 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,350,000.0 | 4,650,000.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 61,353,122.5 | 221,788,160.5 |
| 210401 | Бичиг хэрэг | 9,221,108.5 | 16,601,035.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 36,329,780.0 | 32,214,172.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,422,400.0 | 4,897,800.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,500,000.0 | 110,000,000.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,879,834.0 | 58,075,153.5 |
| **2105** | **Нормативт зардал** | 3,297,000.0 | 5,030,944.0 |
| 210502 | Хоол, хүнс | 600,000.0 | 5,030,944.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,697,000.0 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 50,144,381.5 | 80,130,504.0 |
| 210604 | Урсгал засвар | 50,144,381.5 | 80,130,504.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 13,164,000.0 | 10,902,445.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 13,164,000.0 | 10,902,445.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 179,160,411.0 | 114,532,180.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 179,160,411.0 | 114,532,180.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 650,793,645.9 | 791,792,543.9 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 155,126,536.0 | 32,654,300.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,000,000.0 | 217,000.0 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 492,667,109.9 | 758,921,243.9 |
| **212** | **ТАТААС** | 20,000,000.0 | - |
| **2122** | **Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас** | 20,000,000.0 | - |
| 212201 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 20,000,000.0 | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 251,182,830.8 | 428,318,912.3 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 118,876,709.0 | 50,605,100.0 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | - | 29,370,000.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 32,560,000.0 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 30,022,000.0 | 8,236,000.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 56,294,709.0 | 12,999,100.0 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 132,306,121.8 | 377,713,812.3 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 130,115,209.8 | 377,241,212.1 |
| 213404 | Хөрөнгийн | 2,190,912.1 | 472,600.2 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **36,042,889.0** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 36,042,889.0 |
| 223001 | Бусад хөрөнгө | - | 36,042,889.0 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **3,439,538,369.1** | **1,112,688,985.5** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **3,439,538,369.11** | **1,112,688,985.51** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,562,403,561.00** | **1,898,207,062.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **77,508,100.00** | **4,389,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 77,508,100.00 | 4,389,000.00 |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 77,508,100.00 | 4,389,000.00 |
| **1200042** | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 77,508,100.00 | 4,389,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,484,895,461.00** | **1,893,818,062.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 199,530,661.00 | 215,237,532.00 |
| **131103** | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 181,211,546.00 | 208,642,728.00 |
| **131104** | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 14,537,115.00 | 2,566,004.00 |
| **131105** | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,782,000.00 | 4,028,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 1,285,364,800.00 | 1,678,580,530.00 |
| **132001** | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,285,364,800.00 | 1,678,580,530.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,562,403,561.00** | **1,898,207,062.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,562,403,561.00** | **1,898,207,062.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,291,220,730.16** | **1,454,104,990.71** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 587,670,617.44 | 745,931,472.98 |
| **210101** | Үндсэн цалин | 303,189,410.12 | 332,919,057.03 |
| **210102** | Нэмэгдэл | 214,714,762.45 | 312,895,528.01 |
| **210103** | Унаа хоолны хөнгөлөлт | 12,325,255.27 | 17,714,936.77 |
| **210104** | Урамшуулал | 57,441,189.60 | 69,064,372.00 |
| **210105** | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 13,337,579.17 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 85,460,582.00 | 110,681,760.00 |
| **210201** | Тэтгэврийн даатгал | 58,113,123.48 | 74,904,513.00 |
| **210202** | Тэтгэмжийн даатгал | 6,749,451.70 | 8,803,410.00 |
| **210203** | ҮОМШӨ-ний даатгал | 5,556,914.88 | 4,533,637.00 |
| **210204** | Ажилгүйдлийн даатгал | 1,367,363.18 | 4,551,527.00 |
| **210205** | Эрүүл мэндийн даатгал | 13,673,728.76 | 17,888,673.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 74,930,603.72 | 79,566,796.73 |
| **210301** | Гэрэл, цахилгаан | 13,292,258.02 | 20,320,144.33 |
| **210302** | Түлш, халаалт | 60,288,345.70 | 52,196,652.40 |
| **210303** | Цэвэр, бохир ус | 1,350,000.00 | 7,050,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 59,735,480.00 | 167,124,022.00 |
| **210401** | Бичиг хэрэг | 8,396,000.00 | 3,850,000.00 |
| **210402** | Тээвэр, шатахуун | 36,329,780.00 | 32,214,172.00 |
| **210403** | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,422,400.00 | 4,897,800.00 |
| **210405** | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,500,000.00 | 124,590,050.00 |
| **210406** | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,087,300.00 | 1,572,000.00 |
| **2105** | **Нормативд зардал** | 830,000.00 | 4,395,000.00 |
| **210502** | Хоол, хүнс | 600,000.00 | 4,212,500.00 |
| **210503** | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 230,000.00 | 182,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 59,259,900.00 | 63,644,904.00 |
| **210604** | Урсгал засвар | 59,259,900.00 | 63,644,904.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 13,164,000.00 | 10,902,445.00 |
| **210702** | Дотоод албан томилолт | 13,164,000.00 | 10,902,445.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 187,788,410.00 | 127,305,475.00 |
| **210801** | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 187,788,410.00 | 127,305,475.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 222,381,137.00 | 144,553,115.00 |
| **210901** | Бараа үйлчилгээний бусад зардал | 219,381,137.00 | 141,804,015.00 |
| **210902** | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,000,000.00 | 2,749,100.00 |
| **212** | **ТАТААС** | **20,000,000.00** | **00.00** |
| **2122** | **Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас** | 20,000,000.00 | 00.00 |
| **212201** | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 20,000,000.00 | 00.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **251,182,830.84** | **444,102,071.29** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 118,876,709.02 | 50,605,100.00 |
| **213205** | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 00.00 | 29,370,000.00 |
| **213207** | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 32,560,000.00 | 00.00 |
| **213208** | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 30,022,000.02 | 8,236,000.00 |
| **213209** | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 56,294,709.00 | 12,999,100.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 132,306,121.82 | 393,496,971.29 |
| **213403** | Төвлөрүүлэх шилжүүлэг | 132,306,121.82 | 393,496,971.29 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 682,319,235.76 | 169,471,492.87 | 6,244,835,279.83 | 7,096,626,008.46 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | -82,772,295 | -82,772,295 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 682,319,235.76 | 169,471,492.87 | 6,162,062,984.83 | 7,013,853,713.46 |
| Тайлант үеийн үр дүн | | | 3,371,973,664.11 | 3,371,973,664.11 |
| 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 0.0 | 0.0 | -82,772,295 | -82,772,295 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 682,319,235.76 | 169,471,492.87 | 9,533,969,982.3 | 10,385,760,710.93 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | -565,000 | - | - | -565,000 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 1,244,075,314.94 | 1,244,075,314.94 |
| 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 681,754,235.76 | 169,471,492.87 | 10,778,045,297.24 | 11,629,271,025.87 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 153,497.6 мянган төгрөгийн 3 алдаа[1] илэрснээс аудитын явцад алдааг залруулга хийсэн.

*Залруулсан алдаа:*

- Санхүүгийн тайланг бэлтгэхдээ хүчингүй болсон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу бэлтгэсэн
- Үр дүнгийн тайлангийн цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг тодруулга тайлангийн цалингийн өглөгтэй тулган баталгаажуулахад 143,497.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан,
- Үр дүнгийн тайлангийн Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардлыг 10,000.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь УСНББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", батламж мэдэгдлийг хангахгүй байна

### 5.1 Төлбөрийн акт

Тайлант онд төлбөрийн акт тогтоогүй байна.

### 5.2 Албан шаардлага

*Илрүүлэлт* Тайлан онд нягтлан бодогчид 3,118.0 мянган төгрөгийн балансын урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "*хариуцлагатай байх*", 6 зүгээр зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", 16 дугаар зүйлийн 16.5.2-д "*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*", 16.5.5-д "*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

*Илрүүлэлт*

Төсвийн хөрөнгөөс 2,543.0 мянган төгрөгөөр спортын уралдаан тэмцээн зохион байгуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "*Үнэн зөв байх*", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.8-д "*байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах*ыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

### 5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй болно.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | *Залруулсан* | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайланг бэлтгэхдээ хүчингүй болсон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу бэлтгэсэн | 1 | - | | | 1 | - | 1 | - | | | | |
| Үр дүнгийн тайлангийн цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг тодруулга тайлангийн цалингийн өглөгтэй тулган баталгаажуулахад 143,497.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан | 1 | 143,497.6 | | | 1 | 143,497.6 | 1 | 143,497.6 | | | | |
| Үр дүнгийн тайлангийн Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардлыг 10,000.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан | 1 | 10,000.0 | | | 1 | 10,000.0 | 1 | 10,000.0 | | | | |
| **Дүн** | **3** | **153,497.6** | | | **3** | **153,497.6** | **3** | **153,497.6** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Нягтлан бодогчид 3,118.0 мянган төгрөгийн балансын урамшуулал олгосон | 1 | 3,118.0 | | | 1 | 3,118.0 | | | | | | |
| Сумын онцгой комиссын гишүүдийн нормын хувцасд 1,530.0 мянган төгрөг зарцуулсан | 1 | 1,530.0 | 1 | 1,530.0 | | | | | | | | |
| Төсвийн хөрөнгөөс 2,543.0 мянган төгрөгөөр спортын уралдаан тэмцээн зохион байгуулсан | 1 | 2,543.0 | | | 1 | 2,543.0 | | | | | | |
| **Дүн** | **3** | **7,191.0** | **1** | **1,530.0** | **3** | **5,661.0** | | | | | | |